



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

Дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, тус газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Оасисмон ХХК-ийн “Оасисмон” дэн буудлын 18/373, Буян даш ХХК-ийн “Од” дэн буудлын 18/106, Билэгт учрал ХХК-ийн “Билэгт учрал” дэн буудлын 18/352, Ар улаан чулуу ХХК-ийн “Соко” дэн буудлын 18/354, Манкур ХХК-ийн “Манкур” дэн буудлын 18/369 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.


5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500335

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 09
сарын 23 өдрийн А/77 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



**ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2019 оны 09 дүгээр сарын 23-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Оасисмон ХХК	5678714	Оасисмон	БЗД-ийн, 12-р хороо, Чулуутын 1-10 тоот
2	Буян даш ХХК	5913519	Од	СХД-ийн, 6-р хороо, Тоосгоны 3-34а
3	Билэгт учрал ХХК	5264103	Билэгт учрал	СХД-ийн, 2-р хороо, Орбит 21-368
4	Ар улаан чулуу ХХК	2699435	Соко	СХД-ийн, 18-р хороо, Өнөр хороолол 13а
5	Манкур ХХК	2881039	Манкур	БГД-ийн, 16-р хороо, Туулын 19-386 тоот

-ooOoo-